

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.8.1. Ус хангамж, ашиглалт	8
1.8.2. Дулаан хангамж.....	9
1.8.3. Цахилгаан хангамж	9
1.8.4. Хог хаягдал.....	10
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	19
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
4.1. Байгаль орчны менежментийн арга хэмжээ ба үүрэг	21
4.2. Байгаль орчны дотоод хяналт шалгалт	22
4.3. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	23
4.4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж.....	24
4.5. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	29
4.6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	30
4.7. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	30
4.8. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	30
4.9. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	30
4.10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	31
БҮЛЭГ II. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжиж буй талбайн координат цэг.....	2
Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим	4
Хүснэгт 3. Хуулах шимт хөрсний хэмжээ	4
Хүснэгт 4. Чулуулгийн физик механикийн шинж чанар	4
Хүснэгт 5. Nanjin 16BT өрмийн машины техникийн тодорхойлолт.....	5
Хүснэгт 6. Уурхайд хэрэглэгдэх усны зарцуулалтын тооцоо	9
Хүснэгт 7. Сарын дундаж агаарын температур /°C-ээр/.....	11
Хүснэгт 8. Нийлбэр хур тунадасны хэмжээ /мм-ээр/.....	12
Хүснэгт 9. Хур тунадастай холбоотой үзэгдлүүдийн давтагдал /1988-2018/.....	12
Хүснэгт 10. Сарын дундаж хөрсний гадаргын температур /°C-ээр/, (1990-2020).....	14
Хүснэгт 11. Хөрсний химийн үндсэн үзүүлэлт	17
Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүн	17
Хүснэгт 13. Хөрсний хүнд металл.....	17
Хүснэгт 14. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийн уялдаа	19
Хүснэгт 15. Ордын ашиглалтын үед сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	24
Хүснэгт 16. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	29
Хүснэгт 17. Төслийн явцад хэрэгжүүлэх түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	30
Хүснэгт 18. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	30
Хүснэгт 19. Хог хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	31
Хүснэгт 20. Байгаль орчныг хамгаалах зардлын нэгдсэн хүснэгт	31
Хүснэгт 21. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал.....	33
Хүснэгт 22. БОМТ-ний хэрэгжилтийн талаар нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах хуваарь	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил.....	2
Зураг 2. Уурхайн харагдах байдал.....	3
Зураг 3. Гадаад тээврийн маршрут	6
Зураг 4. Гар ялгалтын технологийн схем	7
Зураг 5. Тоног төхөөрөмжийн холболт	8
Зураг 6. Худгийн байршил	8
Зураг 7. Худаг.....	16

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч: “Межик бридж” ХХК

УБД: 9011113121, РД: 5175933

Төслийн нэр: “Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл


Төслийн зорилго: Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлж жонш олборлох

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: МУ-019018

Төслийн талбайн байршил: MV-019018 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 505.45 га талбай бүхий Цогзол уул жоншны орд нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос урагш 310 км, Өлзийт сумын төвөөс баруун хойш 20 км зайд байрлана.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжиж буй талбайн координат цэг

№	Уртраг	Өргөрөг
1	106° 10' 1.34"E	45° 07' 56.55"N
2	106° 09' 1.34"E	45° 07' 56.55"N
3	106° 09' 1.34"E	45° 10' 1.55"N
4	107° 10' 1.34"E	45° 10' 1.55"N



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил





Зураг 2. Уурхайн харагдах байдал

1.2. Төслийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

Цогзол уулын орд нь 2015 оны 07-р сарын 27-ны өдөр MV-019018 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг авч байсан. Мөн 2021 онд БОАЖЯ-аас Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулж 2022 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгон батлуулсан.

1.3. Төслийн хүчин чадал

Уурхайн хүчин чадлыг захиалагч байгууллагаас өгсөн төслийн даалгаварыг үндэслэн эхний жилд 30.0 мян.тн, 2,3,4-р жилд 90.0 мян.тн, 5-р жилд 75.3 мян.тн хүдэр олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байна. Ордын нийт үйлдвэрлэлийн нөөц нь 406.4 мян.тн байна. Уурхайн нийт ажиллах хугацааг 5 жил байхаар тооцсон. Уурхайн нь жилд 6 сар буюу 160 хоног, хоногт 10 цагаар 2 ээлжээр ажиллах бөгөөд ажиллах хүчин 25 хүн байна.

1.4. Уурхайн ажлын горим

Уулын ажил нь жилд 6 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 10 цагаар явагдана. Үйлдвэрлэлийн бусад ажил болох цахилгаан хангамж, усан хангамж, гэрэлтүүлэг зэрэг үйлдвэрлэлийн дотоод ажлын зохион байгуулалтаар хийнэ. Уурхайн ажиллах горимыг захиалагч байгууллагын

техникийн даалгавар, уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар сонгов.

Хүснэгт 2. Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Календарь хоног	хоног	180
Жилд ажиллах сар	сар	6
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Ээлжийн тоо	ээлж	2
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын саатал	хоног	8
Бэлтгэл ажлын хоног	хоног	2
Жилд ажиллах хугацаа	хоног	160

1.5.Олборлолтын технологи

Уурхайн нээлт: Ил уурхайг газрын гадаргуугаас гадаад траншейгаар нээнэ. Ажлын талбайн хамгийн бага өргөний хэмжээ нь 26м, мөргөцгийн налууугийн өнцөг 75 градус, нээгч траншейн суурийн хамгийн бага өргөний хэмжээ 15м болно.

Хүдрийн биетийн тогтоц, хөрсний овоолгын байршлаас хамааран нээгч траншей нь зүүн урдаас, баруун хойш чиглэсэн байна. Мөн нээлтээр 85.0 мян.м³ хөрс хуулж газрын гадаргын налуу хэсгийг ашиглан гадаад овоолго үүсгэнэ.. Уг төлөвлөлтийн дагуу уурхайн нээлтийн траншей нь X= 591010.0, Y= 4998609.1 координатаас /автокадын/ эхлүүлэхээр уг төсөлд тусгалаа.

Шимт хөрс хуулалтын ажил: Уулын ажил эхлэхийн өмнө үржил шимт хөрсийг газрын гадаргаас ойролцоогоор 0.2 м орчим зузаантайгаар хуулж шимт хөрсний овоолгод байршуулна.

Хүснэгт 3. Хуулах шимт хөрсний хэмжээ

Ил уурхайн эвдрэлд өртөх талбай, м ²	Овоолгын суурь, м ²	Зам, талбай, м ²	Тосгон, м ²	Баяжуулах хэсэг, м ²	Бусад 10%	Нийт эвдрэлд өртөх талбай, м ²	Хуулах шимт хөрсний хэмжээ, м ³
90,275.67	128,589.98	43,299.27	1,907.50	2,385.00	26,645.74	293,103.17	87,930.95

Ил уурхайн ашиглалтын хугацаанд 87.9 мян.м³ шимт хөрс хуулж овоолгод байршуулахаар байна.

Өрөмдлөг тэсэлгээний ажил: Чулуулгийн бат бөхийн коэффициент проф. М.М.Протодьяконовын ангиллаар хөрсний чулуулаг f=7-10, хүдэрт f=8-11, өрөмдлөгийн зэрэглэлээр чулуулаг–VI-XI, хүдэр–IX-X ангилалд хамаарагдаж байна. Ордын чулуулгийн физик-механикийн шинж чанараас хамааруулан уулын цулыг өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 4. Чулуулгийн физик механикийн шинж чанар

Үзүүлэлт	Нэгж	Хөрс	Хүдэр
Өрөмдлөгийн хүндрэлийн харьцангуй үзүүлэлт	-	7.2	9.8
Чулуулгын шахалтын бат бэхийн хязгаар	мПа	59.6	85.5
Чулуулгын шилжрэлтийн бат бэхийн хязгаар	мПа	14.2	25.3
Чулуулгын суналтын бат бэхийн хязгаар	мПа	20.9	31.1
Чулуулгын нягт	тн/м3	2.5	2.6
Хүндийн хүчний хурдатгал	м/с2	9.8	9.8
Бутлалтын хүндрэлийн үзүүлэлт	-	5.5	7.8
Чулуулгын ан цавшлын нөлөөллийг тооцох коэффициент	-	0.85	0.90
Тэсрэх бодисын жишиг хувийн зарцуулалт	г/м3	49.4	68.3
Экскавацлах хүндрэлийн харьцангуй үзүүлэлт		0.73	1.31

Бутлагдсан чулуулгын дундаж хэмжээ	м	0.22	0.22
Чулуулгын сийрэгжилтийн коэффициент		1.25	1.25
Тээвэрлэлтийн хүндрэлийн харьцангуй үзүүлэлт		2.8	4.0
Чулуулгын чийгшилт		0.09	0.09
Чулуулаг дахь шаварлаг хэсгийн агуулга		0.01	0.01
Дотоод үрэлтийн өнцөг	град	32.5	28.0

Тус уурхайн чулуулгийн физик-механикийн шинж чанар, уурхайн жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ зэргийг үндэслэн өрөмдлөгийн ангиллаар дунд зэргийн чулуулаг өрөмдөх зориулалт бүхий өрмийн машин тохиромжтой юм. Иймд Хятад улсад үйлдвэрлэсэн Hanjin 16BT өрмийн машиныг сонгосон байна.

Хүснэгт 5. Hanjin 16BT өрмийн машины техникийн тодорхойлолт

Үзүүлэлт	Х.н	Hanjin 16BT
Өрмийн хошууны диаметр	мм	102-300
Штангийн нийт урт	м	31
Тэнхлэгийн даралт	кН	187
Хошууны эргэлтийн давтамж	сек-1	2
Мушгих момент	Nm	500
Суурилсан чадал	кВт	490
Явах ангийн хурд	км/цаг	4
Үндсэн хөдөлгүүрийн төрөл	-	Дизель
Масс	тонн	14
Түлшний савны хэмжээ	л	650
Урт	м	10
Өргөн	м	3.1
Өндөр /их биеийн/	м	3.2
Өндөр /цамхагаа өргөсөн үеийн/	м	11

Өрмийн төхөөрөмжийн ажиллах талбайг засаж тэгшлэх, бэлдэх төхөөрөмж ба туслах тоноглолыг ажилд бэлдэх, цахилгаан эрчим хүч, өрмийн багаж төхөөрөмж бусад материалаар хангах, өрөмдсөн цооногуудыг эвдрэлтээс хамгаалах, бүртгэл, хэмжилт, төхөөрөмжийн зөөвөр илүүдэл, засварын ажил өөрчлөлт зэрэг олон туслах ажлууд байна. Доголын талбайг өрөмдлөгт бэлдэхдээ талбайд буй саад болох тоног төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах, тэгшлэх, зам засах зэрэг ажлыг голдуу бульдозер хэрэглэж гүйцэтгэнэ. Засаж бэлдсэн талбайд маркшейдерийн хэмжилтээр цооног байрлах тэмдэглэгээг хийх ба шахсан хий, усаар хангах, өрөмдөх төхөөрөмжөө байрлуулж ажилд бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

Тэсэлгээний ажлын тооцоо: Ил уурхайн тэсэлгээний ажлыг 7-14 хоногт нэг удаа хийх ба уулын цулыг энгийн найрлагатай тэсрэх бодис (ANFO)-оор тэслэх ба устай цооногт эмульсийн тэсрэх бодис хэрэглэнэ. Уурхайн тэсэлгээний ажлыг тэсэлгээний тусгай зөвшөөрөлтэй компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүлнэ.

Ухаж ачих процесс: Ухаж-ачих процессд техникийн даалгаврын дагуу Цогзол-Уулын ордод одоо ашиглагдаж байгаа тоног Doosan DX370LC-7 экскаваторыг үргэлжлүүлэн ашиглахаар тусгасан байна.

1.6. Уурхайн тээвэр

Дотоод тээвэр

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд дунджаар 330.0 мян.м³ хөрс хуулж, 90 мян.тн хүдэр олборлоно.


Хөрс тээвэрлэлт. Хөрсийг уурхайн дотор явах замын дундаж зайг оруулан дунджаар 0.9 км зайнд байрлах гадаад овоолгод тээвэрлэнэ.

Хүдрийн дотоод тээвэр. Жилд дунджаар 37.0 мян.м³ буюу 90.0 мян.тн хүдрийг мөргөцгөөс шууд ачиж, хүдэр буулгах талбай хүртэл 1.0 км зайд тээвэрлэнэ.

Уурхай дээр дотоод тээвэрт одоо ашиглагдаж байгаа Howo 20 маркийн автосамосвалыг үргэлжлүүлэн ашиглахаар төлөвлөсөн байна. Хөрс болон хүдэр тээвэрлэлтэд 4 ш автосамосвал байхад бүтээлийг хангахаар байна.

Гадаад тээвэр

“Цогзол-Уул”-ын уурхайн бутлан ангилах хэсгээс гарах баяжмалыг Чойр өртөө хүртэл 220 км зайд 35 тн-ын даацтай автосамосвалаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрээр уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний тээвлэх маршрутын дагуу тээвэрлэнэ. Автомашинны сонголтыг MNS 4598:2011 стандартад нийцүүлэн 2.5м өргөнтэй, 6 голтой, 1 тэнхлэг дээрх даралт 11тн-оос хэтрэхгүй байхаар тооцлоо.




Зураг 3. Гадаад тээврийн маршрут

1.7. Хүдэр баяжуулах хэсэг

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших “Цогзол-уул” хайлуур жоншны ордын “Өлзийт-1” талбайн “Межик бридж” ХХК-ийн жоншны гар ялгалтын үйлдвэрийг жилд дунджаар 90,000 тн хүдрийг уурхайгаас олборлон, гар ялгалтаар ялган ФК-70 маркийн баяжмал гарган авах хүчин чадалтай байхаар төлөвлөсөн. Хүдрийн биетийн эрдэслэг бүрэлдэхүүн нь кварц- флюоритийн гидротермаль бүрдэлд хамаарагдана. Хайлуур жоншны хүдэр нь хайлуур жоншны агуулга болон технологийн шинж чанараас хамааран баян ба ердийн гэж ангилдаг. “Өлзийт-1” талбайн хайлуур жоншны кварцит-флюоритийн төрлийн хүдэр нь нөөцийн 30%- ийг эзэлнэ. Хүдрийн биетэд энэ төрлийн хүдэр дэх флоритийн дундаж агуулга 28%-аас 47.78% хүртэл, кальцит 1.77% -5.35% хүртэл, дундаж агуулга 35.2% байна. Баяжуулах технологи бутлалт шигшилт гар ялгалт гэсэн технологийн дараалалын дагуу явагдана.

“Межик бридж” ХХК-ийн жоншны гар ялгалтын үйлдвэрийг жилд дунджаар 90,000 тн хүдрийг уурхайгаас олборлон, гар ялгалтаар ялган ФК-70 маркийн баяжмал гарган авах хүчин чадалтай байхаар төлөвлөсөн. Жижиг уурхайнуудын хувьд флотацийн баяжмал ФФ 95А-г гарган авах флотацийн үйлдвэр байгуулж, баяжуулалт хийх боломжгүйгээс гадна эдийн засгийн үр ашиг багатай тул хүндийн хүчний туршилтын үр

дүнд үндэслэн гар ялгалтаар агуулга ихтэй хүдрийг ялган авах технологийн схемийг сонгож, холбогдох тоо чанарын тооцооллуудыг хийжээ.



Зураг 4. Гар ялгалтын технологийн схем

Хүдэр бутлах хэсгийн төлөвлөлт

Хүдрийг гараар ялгахад хүдрийн ширхэглэлийн хэмжээ 25-250 мм байх шаардлагатай байдаг бөгөөд ордын хувьд гар ялгалтын аргаар агуулга өндөртэй хүдрийг ялган авах юм. Үүний тулд хүдрийн ширхэглэлийн хэмжээг багасгах зорилгоор бутлалтыг хийх ба энэ нь хүдэр боловсруулалтын бэлтгэл ажиллагаа болох юм. Хүдрийг буталж, шигшсэнээр ашигт бүрдлүүд нь хоосон чулуулгуудаас салахаас гадна ширхэглэлийн хувьд жигдэрч өгдөг. Иймээс ашигт малтмалыг баяжуулахын өмнө заавал буталж, шигших шаардлагатай. Хайлуур жоншны хүдэр нь хатуулаг багатай (Моосын шатлалаар 4) тул ихэвчлэн 1-2 шатны бутлалт, шигшилтын хосолсон схемээр хүдрийг баяжуулалтад бэлтгэдэг. “Өлзийт-1” ордын хайлуур жоншны хүдрийн бутлалтад орох хүдрийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ -250 мм хэмжээтэй ирэх бөгөөд 1 шатны бутлалтад оруулж, /+150/, /-150+50мм/, /-50мм/ гэсэн 3 ангилалд 2 тор бүхий чичиргээт шигшүүрээр шигшинэ.


Үйлдвэрийн ажиллах горим

Үйлдвэрийн ажиллах горимыг ижил төстэй хайлуур жонш баяжуулах үйлдвэрүүдийн жишгийг харгалзан үзэж дараах байдлаар сонгов. Үүнд:

- ✓ Жилийн /календарийн/ 365 хоног
- ✓ Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ 20 хоног
- ✓ Улсын баяр наадам, амралт 15 хоног
- ✓ Төлөвлөгөөт сул зогсолт 177 хоног
- ✓ Жилд ажиллах хоногийн тоо 153 хоног
- ✓ Хоногт ажиллах ээлжийн тоо 1
- ✓ Ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг

Жоншны гар ялгалтын үйлдвэр нь жилд 4-8-р саруудад нийт 153 хоногт, 1 ээлж нь 12 цагаар ажиллана. Тоног төхөөрөмжийн жилд ажиллах хугацаа жилд 1836 цаг, тоног төхөөрөмжийн найдварт ажиллагаа 80,75%.

Үндсэн тоног төхөөрөмжийн сонголт



Зураг 5. Тоног төхөөрөмжийн холболт

1.8. Уурхайн дэд бүтэц, түүхий эд


1.8.1. Ус хангамж, ашиглалт

Төслийн хэмжээнд усыг ажилчдын унд-ахуйн хэрэглээ, зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэнэ. Уг усны хэрэглээг гүний худгаас хангана. Худгийн ундарга нь 3.5 л/сек байна.

Худгийн байршил: 45° 07' 12.00"

106° 11' 60.00"

Д.т.д 1200 м.



Зураг 6. Худгийн байршил

Ажилчдын унд-ахуйн усны хэрэглээ

Оршин суугч нэг хүний хоногийн усны хэрэглээг Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яамны сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтаар нэг ажилчны ээлжинд буюу ажлын байранд хэрэглэх халуун болон хүйтэн усны хэрэглээ 20-200 л/хоног байна.

$$25 \text{ хүн} * 70 \text{ л} = 1.75 \text{ м}^3 / \text{хоног}$$

$$1.75 \text{ м}^3 / \text{хоног} * 160 \text{ хоног} = 280 \text{ м}^3 / \text{жилд}$$

$$280 \text{ м}^3 / \text{жилд} * 5 \text{ жил} = 1.4 \text{ мян. м}^3$$

Нийтдээ ашиглалтын 5 жилийн хугацаанд ахуйн хэрэглээнд 1.4 мян.м³ ус ашиглахаар тооцоо гарч байна.

Зам талбайн усалгаа

Төслийн үйл ажиллагааны үед дотоод тээвэрлэлтэнд 1300 м зам энэ нь 7800 м² талбайг усална гэж тооцлоо. 1м² талбайг 2 л усаар услахаар тооцлоо.

$$7800 \text{ м}^2 * 2 \text{ л/ус} = 15.6 \text{ м}^3 / \text{хоног}$$

$$15.6 \text{ м}^3 / \text{хон} * 80 \text{ хоног} = 1248 \text{ м}^3 / \text{жилд}$$

$$1248 \text{ м}^3 / \text{жилд} * 5 \text{ жил} = 6240 \text{ м}^3$$

Нийт усны хэрэглээ

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолын дагуу ордын талбай нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт багтаж байгаа ба 2013 оны 327 тогтоолын дагуу Усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ 3700 төгрөг/шоо метр, Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр -0.25 байна.

Мөн ажилчдын унд- ахуйн хэрэглээнд 5 жилийн хугацаанд 1400м³ ус, уурхайн замын усалгаанд 6240 м³ ус ашиглахаар тооцоо гарсан байна.

Хүснэгт 6. Уурхайд хэрэглэгдэх усны зарцуулалтын тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Зам талбайн тоос дарах	м ³ /хоног	15.6
2	Ахуй, ундны хэрэглээ	м ³ /хоног	1.75
3	Нийт	м ³ /хоног	17.35

Уурхайн шүүрлийн ус

Орд газрын орчимд урсгал ус байхгүй. Хүдрийн биетүүд дээр өрөмдөгдсөн 80м хүртэл гүнтэй цооногуудад усны давхарга илрээгүй, хөндий хоолойд өрөмдөгдсөн худгуудын усны түвшин нь хүдрийн биетүүдийн төвшингөөс хэдэн арав, зуун метрийн доор байрлалтай байдаг. Ордын гидрогеологийн нөхцөл байдал нь хуурай, хөрсний болон гүний усны ямар нэгэн илрэл ажиглагдаагүй учир гидрогеологийн ямар нэгэн хүндрэл байхгүй.

1.8.2. Дулаан хангамж

Төсөл хэрэгжих хугацаа нь дулааны улирал буюу 4,5,6,7,8,9,10-р сарууд байх тул дулааны хэрэглээ гарахгүй ба шаардлагатай тохиолдолд бага оврын зуухыг ашиглана.

1.8.3. Цахилгаан хангамж

Уурхайн нийт цахилгааны хэрэглээг 50 кВт болон 160 кВт-ийн чадалтай дизель үүсгэвэрээр хангахаар төлөвлөсөн. Уурхайд бутлан ялгах хэсэг, ил уурхайн гэрэлтүүлэг, хотхоны гэсэн цахилгаан хэрэглэгч байна.

Дизель станц

Төвийн нэгдсэн эрчим хүчний системээс алслагдсан ба эрчим хүч хүрээгүй аймаг сум газруудад болон улсын нэн чухал объектуудад эх үүсвэр болгон дизелийн цахилгаан станцыг ашигладаг.

Тооцоог үндэслэн өдрийн цагаар бутлах хэсэг, засварын цех ажиллаж байх үед БНХАУ-д үйлдвэрлэсэн Mega power solution үйлдвэрийн MP-212C-60 маркийн 160 кВт чадалтай дизель цахилгаан үүсгэвэр, аж ахуйн хэрэгцээнд болон ил уурхайн гэрэлтүүлэгт MP-68C-60 маркийн 50 кВт дизель генератор сонгож авлаа.

1.8.4. Хог хаягдал

Ахуйн хатуу хог хаягдал

Тус төслийн хэмжээнд нийт 25 хүн ажиллана гэж тооцвол хоногт 12.5 кг, жилд 160 хоног ажиллана гэвэл 2.0 тн хатуу хог хаягдал, ашиглалтын 5 жилийн хугацаанд 10.0 тн хатуу хог хаягдал гарахаар байна

Дээрх тооцоог 1 хүн өдөрт дунджаар 0.5 кг хатуу хог хаягдал гаргахаар тооцож гаргалаа.

Ахуйн шингэн хог хаягдал

Үйл ажиллагааны үед унд-ахуйн хэрэглээнээс шингэн хаягдал гарна. Унд ахуйн шингэн хаягдлын хэмжээг тооцохдоо нийт хэрэглээний 80% гэж үзэв. Шингэн хаягдлын хэмжээ жилд 480 м³ буюу 5 жилийн хугацаанд 2.4 мян.м³ ахуйн шингэн хаягдал гарах тооцоотой байна. Төслийн төлөвлөгөөнд уг шингэн хаягдлыг бохирын цооногт хуримтлуулахаар төлөвлөжээ.

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Төсөл хэрэгжих талбай орчмын цаг уур, уур амьсгалын онцлог

Дэлхийн Цаг Уурын Байгууллагаас цаг уурын өртөө орчмын 50 км радиуст орших газар нутгуудад, тухайн өртөөний цаг уурын хэмжилтийн утгыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Иймд төслийн объект орчмын уур амьсгалын тодорхойлолтыг цаг уурын “Өлзийт” харуул болон “Мандалговь” өртөөний олон жилийн ажиглалтын мэдээн дээр тулгуурлан бичлээ. Цаг уурын “Мандалговь” өртөө 1944 онд байгуулагдсан. “Өлзийт” харуул хойд өргөргийн 44°56', зүүн уртрагийн 106°19'-т, далайн түвшнээс дээш 1100 м орчим өндөрт оршино.

2.2. Агаарын температур

Тус ашиглалтын талбайд хамгийн ойр цаг уурын “Өлзийт” харуул орчимд сүүлийн 30 жилийн дундаж (1990-2020) агаарын температурын утга 2.0°C, харин талбайн баруун урд 30 гаруй км-ийн зайд орших боловч далайн түвшнээс дээших өндөр ойролцоо “Өлзийт” харуул дээр харьцангуй дулаан 3.2°C байдаг.

Хүснэгт 7. Сарын дундаж агаарын температур /°C-ээр/

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	жил
Өлзийт	-18.6	-14.3	-6.1	4.3	12.4	18.6	21.0	18.8	11.6	1.9	-9.1	-16.4	2.0
T _{max}	2.8	8.0	20.7	30.0	33.4	37.5	38.5	38.0	29.7	22.7	17.6	4.2	38.5
T _{min}	-35.0	-33.6	-29.0	-17.8	-9.1	0.4	0.0	1.0	-7.8	-18.9	-31.7	-32.5	-35

Хүснэгтээс үзвэл цаг уурын “Өлзийт” харуул орчимд өвлийн саруудын агаарын температурын дундаж -14.3°C÷-18.6°C дулаан байна. Зуны саруудын агаарын температурын дундаж Өлзийт сум орчимд 18.6°C÷21.0°C байдаг. Шилжилтийн улирал буюу хавар болон намрын саруудын агаарын температурын дундаж харгалзан Өлзийт орчимд -6.1°C÷12.4°C ба -9.1°C÷11.6°C орчимд дулаан байдаг. Өлзийт сумын орчимд аль ч улиралд дулаан байгаа шалтгаан нь агаарын температур газрын гадаргаас эхлэн буурдаг ерөнхий зүй тогтолтой холбоотой. Агаарын үнэмлэхүй их температур сүүлийн 30 жилд Өлзийт сум орчимд харгалзан өвөл I сард 2.8°C ба 4.7°C, хавар IV сард 30.0°C ба 30.7°C, зуны VII сард 38.5°C ба 38.7°C-д хүрсэн бөгөөд зуны сүүлч VIII сард бүүр 39.2°C хүрч халсан. Харин намар X сард харгалзан 22.7°C болон 24.5°C ажиглагджээ.

Тэгвэл дээрхи хугацаанд цаг уурын “Өлзийт” харуул дээр үнэмлэхүй бага температур өвөл I сард аль алинд -35.0°C-д хүрч хүйтэрсэн. Үнэмлэхүй бага температурын утга харгалзан хавар IV сард -17.8°C ба -16.3°C, зун VII сард 0.0°C ба 6.7°C, харин намар X сард -18.9°C ба -18.0°C хүрч хүйтэрсэн байна.

Эндээс агаарын үнэмлэхүй их, бага температурын өндөр утга цаг уурын “Өлзийт” харуул дээр ажиглагдаж байгаа явдал нь энэ сумын уур амьсгал илүү эрс тэс, агаарын чийгшлийн хэмжээ бага байгааг илэрхийлнэ.

Агаарын температурын жилийн амплитуд сүүлийн 30 жилийн сарын дундаж агаарын температурын утгаар цаг уурын “Өлзийт” харуул дээр харгалзан 39.6°C ба 39.4°C, агаарын үнэмлэхүй хамгийн их, бага температурын утгаар харгалзан 73.5°C ба 74.4°C буюу жилийн доторхи дулаан хүйтний хэлбэлзэл харьцангуй өндөр байдаг байна. Агаарын температурын олон жилийн цуваанаас үзвэл тус сумын орчимд хамгийн дулаан жил 2007 он бөгөөд олон жилийн дунджаас 2.9°C-ээр дулаан, хамгийн хүйтэн жил 1998 он ба олон жилийн дунджаас 1.9°C-ээр хүйтэн байсан. Өлзийт орчимд агаарын дундаж температур полином хамаарлаар өсөх хандлагатай тухайлбал 1991-2000 оны дундажийг 2001-2010 оны дундажтай харьцуулахад 1.6°C-ээр дулаарсан байна.

2.3. Агаарын чийгшил, хур тунадас

Өлзийт орчимд олон жилийн дунджаар (1990-2010) жилдээ 97.1 мм хур тунадас унах бөгөөд 92.0% нь жилийн дулаан улиралд буюу IV-IX сарын хооронд орно. Жилийн хүйтэн улиралд орох хур тунадасны хэмжээ бага, сарын дундаж Өлзийт сумын орчим 0.7-2.8 мм хооронд хэлбэлзэнэ.

Сар бүр унадаг нийлбэр хур тунадасны хэмжээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. Нийлбэр хур тунадасны хэмжээ /мм-ээр/

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Өлзийт	0.7	0.7	1.3	2.5	9.6	17.7	27.4	21.7	10.4	2.8	1.3	1.0	97.1
RR _{max}	5.9	4.6	9.7	14.7	37.7	47.5	122.4	72.2	30.9	11.1	5.7	4.5	122.4

Дэрээх хүснэгтээс үзвэл Өлзийт сум орчимд өвлийн саруудад харгалзан 0.7-1.0 мм ба 0.5-1.1 мм, хавар 1.3-9.6 мм ба 2.2-7.2 мм, зуны улиралд харгалзан 17.7-27.4 мм болон 13.9-30.9 мм хур тунадас ордог бол намартаа 1.3-10.4 мм ба 1.2-9.5 мм хур тунадас унана. Хүснэгтийн 2 дугаар мөрөнд тухайн сард орсон хамгийн их хур тунадасны тоо хэмжээг үзүүлсэн бөгөөд цаг уурын “Өлзийт” харуул дээр 1998 оны VII сард 122.4 мм хур тунадас орсон байна. Хоногт орсон хамгийн их хур тунадасны хэмжээг үзэхэд цаг уур “Өлзийт” харуул дээр 2016 оны VI сарын 13-ны өдөр 45.3 мм ажиглагдсан байна.

Нийлбэр хур тунадасны сүүлийн 30 жилийн дундажаас үзвэл Өлзийт орчимд бараг өөрчлөлтгүй гэж үзэж болохоор байна. Тухайлбал эхний 10 жилийн дундаж (1998-2008) утгыг, дараагийн 10 жилийн дундажтай (2008-2018) харьцуулахад нийлбэр хур тунадас 11.4 мм-ээр өссөн. Харин хоёрдугаар 10 жилийн дундаж (1998-2008) утгыг сүүлийн 10 жилийн дундаж (2008-2018) утгатай харьцуулахад 9.7 мм-ээр буурсан.

Хүснэгт 9. Хур тунадастай холбоотой үзэгдлүүдийн давтагдал /1988-2018/

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Бороотой өдрийн тоо	-	-	-	0.1/1	0.8/5	2.6/11	3.9/10	3.9/14	3.4/10	1.3/5	0.3/2	-	16.2/33
Цастай өдрийн тоо	1.8/7	1.6/9	1.9/8	1.6/5	0.3/2	-	-	-	0.1/1	1.5/6	2.1/9	2.1/7	12.9/24

Тайлбар: Үзэгдэлтэй өдрийн тооны хүртвэрт олон жилийн дундаж, хуваарьт ажиглалтын бүх хугацаанд тохиолдсон хамгийн их давтагдалтай жилийн утгуудыг үзүүлэв.

Дээрх хүснэгтийн 1 дүгээр мөрөнд бороотой өдрийн тоог үзүүлсэн ба Өлзийт орчимд бороотой өдрийн тоо жилд ойролцоогоор 16 байна. Энд бороотой өдрийн тоо хамгийн олондоо 2008 онд 33 өдөр байсан бол 1988 онд 28 өдөр байв. Тус сумын хувьд зуны улиралд 10-11 өдөр бороо ордог буюу жилийн нийт бороотой өдрийн 65% нь ноогдоно.

1988-2018 оны бороотой өдрийн дундаж болон сүүлийн 10 жилийн энэхүү үзүүлэлтийн дундаж хоорондын зөрүү 1.2 буюу бороотой өдрийн тоо 1 өдрөөр нэмэгдсэн хэдий ч бороотой өдрийн тооны олон жилийн явцаас харахад бага хэмжээгээр буурах хандлага илэрч байна. Ерөнхийдөө Дундговь аймгийн зарим сумдад өдрийн максимум температур, шөнийн минимум температурын зөрүү (амплитуд) нэмэгдсэнээс аадар бороотой өдрийн давтагдал өсч, харин зүс болон шиврээ борооны давтагдал буурч байна гэж дүгнэхээр байна (MARCC, 2014).

Хүснэгтийн 2 дугаар мөрөнд 1988-2018 онд ажиглагдсан цастай өдрийн тоог үзүүлээ. Өлзийт орчимд цастай өдрийн тоо жилд ойролцоогоор 13 байна. Цастай өдрийн тооны олон жилийн явцаас үзвэл хамгийн их утга 2010 онд 24 өдөр, 2002 онд 23 өдөр байв. Сар тус бүрээр авч үзвэл 2005 оны II сард 9 өдөр, 2000 оны XI сард мөн 9 өдөр, 1991 оны III сард 8 өдөр цастай байв.

Цастай өдрийн тооны олон жилийн явцаас үзвэл цаашид өсөх хандлага тодорхой илэрч байна. Жишээлбэл 1988-2018 оны цастай өдрийн тооны дундаж, сүүлийн 10 жилийн дундаж хоорондын зөрүү 2.5 өдөр буюу 2-3 өдрөөр нэмэгдсэн байна. Дээрхи байдлаар харьцуулж үзэхэд өвөл цастай өдрийн тоо 2 гаруй өдрөөр, хавар энэ үзүүлэлт бараг 2 өдрөөр, харин намар 1 өдрөөр тус тус нэмэгджээ.

2.4. Агаарын даралт, салхи

Агаарын даралтын норм буюу 1961-1990 оны дундажыг 1990-2020 оны дундажтай жишиж үзэхэд өвөл II болон XII сард харгалзан 0.2 ба 0.4 гПа-аар, хавар IV, V сард 0.2-0.4 гПа-аар, зуны саруудад харгалзан 0.1, 0.7 болон 0.5 гПа-аар, намар X сард 0.2 гПа-аар тус тус өссөн. Тэгвэл өвөл I сард 0.1 гПа-аар, хавар III сард 0.2 гПа-аар, намар IX болон XI сард харгалзан 0.2 ба 0.5 гПа-аар буурсан байна. Агаар даралтын жилийн дундажын хувьд 0.2 гПа-аар өсчээ.

Мандалговь орчмын агаарын даралтын сарын явцаас үзвэл I сараас (861.0 гПа) эхлэн буурсаар VII сард (853.6 гПа) хамгийн бага утгандаа хүрээд, цаашид агаарын даралт X сар (862.1 гПа) хүртэл өсч, харин XI сард 0.9 гПа-аар буураад, эргээд 0.3 гПа-аар өснө.

Дээрх хүснэгтийн 3 болон 4 дүгээр мөрөнд “Мандалговь” цаг уурын өртөөн дээр сүүлийн 30 жилд хэмжигдсэн хамгийн их ба хамгийн бага агаарын даралтын дундажыг үзүүлээ. Эндээс үзвэл агаарын даралтын хамгийн их утгын жилийн дундаж 869.3 гПа, энэ үзүүлэлтийн жилийн явцаас үзэхэд хамгийн их хэмжээндээ тогтвортой агаарын хүйтэн масс тогтохоос өмнө X сард 874.0 гПа хүрнэ.

“Мандалговь” өртөөн дээр цаг уурын хэмжилт хийж эхлэснээс хойш агаарын даралтын хамгийн их утга 1994 оны X сард 892.6 гПа хэмжээтэй ажиглагджээ. Агаарын даралтын энэхүү хамгийн их утгын олон жилийн дундаж агаарын даралтын утгаас хазайх харьцангуй хазайлт 4%-тай тэнцүү өөрөөр хэлбэл Мандалговь орчимд агаарын даралт хамгийн ихдээ олон жилийн дундаж агаарын даралтын утгын 4%-тай тэнцүү хэмжээтэй өсдөг гэсэн үг юм.

Агаарын даралтын хамгийн бага утгын жилийн дундаж 845.5 гПа, дээрхи үзүүлэлтийн жилийн явцаас үзвэл хамгийн бага хэмжээндээ дулаан тогтвортой агаарын масс суурьшихаас өмнө IV сард 841.7 гПа хэмжээтэй байв.

“Мандалговь” өртөөн дээр агаарын даралтын хэмжилт хийж эхлэснээс хойш агаарын даралтын хамгийн бага утга 1956 оны III сард 825.7 гПа ажиглагдсан. Агаарын даралтын энэхүү хамгийн бага утгын олон жилийн дундаж агаарын даралтаас хазайх харьцангуй хазайлт 3.8%-тай тэнцүү өөрөөр хэлбэл Мандалговь орчимд агаарын даралт хамгийн багадаа олон жилийн дундаж агаарын даралтын утгын 3.8%-тай тэнцүү хэмжээтэй буурдаг болохыг илэрхийлнэ.

2.5. Хөрсний температур

Хөрсний гадаргын дулаан хүйтний горимыг тодорхойлоход цаг уурын “Өлзийт” харуул дээр хэмжсэн утга ажлын шаардлагыг хангахгүй байна. Учир нь хөрсний гадаргын температурыг хоногт ердөө 2 удаа хэмждэг, мөн хэмжилтийн цуваа тасралт ихтэй байв. Иймд хөрсний дулаан хүйтний горимыг тодорхойлохдоо цаг уурын “Өлзийт” өртөөний сүүлийн 30 жилийн хөрсний гадаргын температурын дундаж, үнэмлэхүй их, бага утгыг ашиглалаа.

Хөрсний гадаргын температурын норм буюу 1981-2010 оны сар болон жилийн дунджийг дараах хүснэгтийн эхний мөрөнд оруулав. Харин хүснэгтийн 2 дугаар мөрөнд сүүлийн 30 жилийн хөрсний гадаргын температурын сар, жилийн дунджийг (цаашид

олон жилийн дундаж гэж нэрлэнэ) үзүүлсэн бөгөөд энэ хэмжигдэхүүний олон жилийн дундаж нормоосоо жилийн хувьд 1.2°C-ээр, хүйтний улирлын хувьд I, XII сараас бусад саруудад 0.1-2.4°C-ээр, дулааны улирлын хувьд 1.1-2.0°C-ээр давж дулаарсан байна. Харин I болон XII саруудад харгалзан 0.8°C ба 1.0°C-ээр хүйтэрсэн.

Өлзийт орчимд хөрсний гадаргын жилийн дундаж температур 4.4°C байна. Олон жилийн дунджаар I сард хамгийн хүйтэн -18.4°C, VII сард хамгийн дулаан 25.4°C орчим байна. Хөрсний гадаргын үнэмлэхүй хамгийн их температур 67÷68°C /2010 оны YII сарын 27-нд/, үнэмлэхүй хамгийн бага температур -45÷-46°C /1944 оны II сарын 11-нд/ ажиглагдсан.

Хүснэгтийн 3 болон 4 дүгээр мөрөнд сар, жилийн хөрсний гадаргын хамгийн их болон хамгийн бага температурын олон жилийн дунджийг мөн үзүүллээ. Эндээс үзвэл хөрсний гадаргын хамгийн их температурын утга бүх сард эерэг өвлийн саруудад 3.7-13.5°C, зундаа 55.9-59.5°C, шилжилтийн улирлуудад 17.9-54.0°C байдаг. Тэгвэл хөрсний гадаргын хамгийн бага температурын утга зуны саруудаас бусад сард сөрөг, хүйтний улиралд -16.0÷-33.7°C байлаа.

Хүснэгт 10. Сарын дундаж хөрсний гадаргын температур /°C-ээр/, (1990-2020)

Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	жил
T _{НОРМ}	-17.6	-15.1	-5.9	5.7	15.4	21.7	23.4	20.8	12.9	2.5	-9.0	-15.9	3.2
T _{ground}	-18.4	-13.5	-3.6	7.4	16.5	23.3	25.4	22.6	14.7	3.6	-8.9	-17.0	4.4
T _{gr.max}	3.7	13.5	29.2	42.8	54.0	59.4	59.5	55.9	49.4	36.0	17.9	4.2	59.5
T _{gr.min}	-33.7	-31.0	-25.7	-14.8	-7.0	1.1	6.1	3.9	-6.4	-16.0	-26.5	-32.0	-33.7

Дараах зургаар агаарын болон хөрсний гадаргын, мөн хөрсний гадаргын хамгийн их, бага температурын сарын дундаж температурын жилийн явцыг үзүүлэв. Эндээс үзвэл хөрсний гадаргын температурын жилийн амплитуд сарын дундаж температураар 43.8°C, хамгийн их, бага температурын дунджаар 93.2°C, үнэмлэхүй хамгийн их, бага температураар 112-114°C буюу жилийн доторхи дулаан хүйтний өндөр хэлбэлзэлтэй байдаг.

2.6. Геологийн тогтоц

“Цогзол уул”-ын хайлуур жоншны ордын нөөцийн тооцоог хийхдээ Бэрх, Бор Өндөр, Хажуу-Улаан, Хар Айраг болон Дундговийн районд байрлах хайлуур жоншны томоохон ордуудын жишиг үзүүлэлтүүдийг үндэс болгон “Цогзол уул”-ын ордын “Өлзийт-1”, “Цогзол уул” нэртэй хүдрийн биетүүдийн хэлбэр хэмжээ, зузаан болон агуулга, тэдгээрийн хувирамтгай чанар, сунал болон уналын дагуу жигд буюу тогтвортой байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан зөвхөн доорх жишгийн үзүүлэлтүүдийг сонгон авчээ.

- ✓ Хүдрийн биетийн хил заагийг тогтооход зориулагдсан малталт дахь захын агуулга-15%
- ✓ Нөөцийн хэсэгчилэл дэх үйлдвэрлэлийн хамгийн бага агуулга-30%
- ✓ Хүдрийн биет доторхи хоосон чулуулгийн хамгийн их зузаан-2.0м
- ✓ Хүдрийн биетийн хамгийн бага зузаан-1.0м

Бага зузаантай, өндөр агуулгатай буюу эсвэл их зузаантай, бага агуулгатай жоншны судалд метрпроцент-28

2.7. Усны сүлжээ

Тухайн район нь гидрогеологийн мужлалаар уулс хоорондын хотгор ихэвчлэн артезийн ус тархсан мужид багтана. /Н.А.Маринов 1963 он/. Судалгааны талбайд тархсан гүний, бялхмал, хувирмал чулуулагт ан цавын, цэрд-дөрөвдөгчийн сэвсгэр

хурдсанд нүх сүвийн ус тархжээ. Мөн гидравлик шинж чанараараа чөлөөт гадаргуутай, түрэлттэй ус тархсан байна.

Дүүргийн хэмжээнд газрын доорхи усны агуулагдсан чулуулгийн стратиграфийн ангилал, найрлага, газрын доорхи усны хөдөлгөөн, тархалт байрлалын нөхцөлүүдээс нь хамааруулан дараах уст үе, давхаргуудыг ялгасан байна. Үүнд:

1. Дөрөвдөгчийн хурдасны уст үе \
2. Цэрдийн хурдас чулуулаг дахь уст давхарга
3. Дээд пермийн Дэлгэрхангай формацийн хурдас чулуулаг дахь ан цавын уст давхарга:
4. Палеозойн гүний чулуулгийн ан цавын уст давхарга
5. Неопротерозойн карбонат ба хувирмал чулуулгийн уст давхарга

2014 онд “Межик Бридж” ХХК-ийн инженер ахлах геологич Очирбат, “Хүрд-Ус” ХХК-ийн гидрогеологич Д.Хишигтогтох нар харилцан тохиролцож гэрээний дагуу “Өлзийт-1” хайлуур жоншны ордын уурхайн усны хайгуул судалгааны ажил явуулсан. Судалгааны ажилд Ч.Коля даргатай, А.Нэргүй мастертай хийн цохилтод өрөмдлөгийн бригад гидрогеологич Д.Хишигтогтохын удирдлага доор ажиллаж “Өлзийт-1” талбайд хийгдсэн өмнөх судлаачидын геофизикийн судалгаа, Дундговийн усны аж ахуйн байгууллагын усны хайгуулын чиглэлээр хийгдсэн ажлуудтай танилцаж газар дээр нь очиж, туршилтын шавхалт, анхан шатны материал боловсруулсан байдаг.

Ашиглалтын судалгааны талбай болон зэргэлдээх районы хэмжээнд газрын доорхи усны үүссэн нөхцөл, тэжээгдлийн эх үүсвэр болон газрын доорхи усны урсгал буюу эргэлтийн цикл, ус агуулагч чулуулгийн стратиграфи-литологийн шинж чанар зэргээс хамаарч дараахь насны хурдас чулуулгийн уст үе, давхаргууд тархсан байдаг.

Үүнд:

1. Дөрөвдөгчийн насны сэвсгэр хурдас чулуулаг дахь нүх сүвэрхэг уст давхрага
 2. Неопротерозойн насны тунамал ба хувирмал чулуулгийн ан цавын уст давхарга
- Дөрөвдөгчийн насны сэвсгэр хурдас чулуулаг дахь нүх сүвэрхэг уст давхрага:*

Дөрөвдөгчийн хурдасны уст үе нь хуурай сайруудын дагуу түүнчлэн жижиг нуурын хотгоруудад үүссэн пролювийн, аллюви-пролювийн болон нуурын гаралтай хурдсанд тархсан байна.

Ус агуулагч чулуулаг нь хайрга, дайрга, шавранцар, элсэнцэр болно. Хуурай сайрын дагуу тархсан пролювийн гаралтай хурдасны зузаан нь 1-3 м, уст үеийн зузаан нь 2м хүрдэг. Энд муу мөлгөржсөн хэмхдэст хурдас зонхилно.

Уг хурдсанд олон тооны гар худаг байрладаг. Агаарын хур тунадас ихтэй жилд эдгээр худгуудыг ашигладаг. Бага байх тохиолдолд гар худгууд хуурайшдаг байна. Үүнээс үзэхэд уг уст давхаргын гол тэжээгч нь агаарын хур тунадас юм.

Дөрөвдөгчийн уст үе газрын гадаргууд ойр оршдог тул /0,5-3,0м / усаа ууршилтаар ихээр алдаж, бага хэмжээгээр гипсометрийн хувьд дор байрлах бусад уст үе, давхаргуудад алддаг байна. Ууршилтанд ихээр өртөх нь усны химийн найрлагад эрдэсжилт ихйэхэд нөлөөлдөг.

Уг уст үе давхаргын усны химийн найрлага нь сульфатлаг, сульфат-хлорлог, хлорлог кальци-натрийн, натрийн найрлагатай. Эрдэсжилт нь 0,8-1,5 г/л, хааяа 2 г/л түүнээс дээш байдаг. Нутгийн ардууд уг уст давхаргын усыг унд болон ахуйн хэрэгцээнд хэрэглэдэг.

Неопротерозойн насны тунамал ба хувирмал чулуулгийн ан цавын уст давхарга:

Ус агуулагч чулуулаг нь ан цавархаг гантигжсан шохойжин, гантиг, кварцит, шохойлог доломит, метаалевролит, элсжин зэргээс бүрэлдэн тогтоно. Усны гүний түвшин 0,5-8,0 м, ундарга 0,05-3,4л/с гэж тогтоосон байдаг.

Эрдэсжилт 1,2-1,6 г/л сулавтар давсархаг, хлорлог, сульфатлаг, натрийн төрлийн найрлагатай. Усны ерөнхий хатуулаг 5,0-8,1мг экв/л. Карбонат чулуулгийн захын хэсгээр буюу тасрал эвдрэлд өртсөн хэсгээр ан цав-карстын усны үлэмжхэн нөөц байж болох талтай.

Хувирмал чулуулаг нь карбонат чулуулагтай хиллэн багахан талбайд тархжээ. Ус агуулагч чулуулаг нь ан цавтай янз бүрийн найрлагатай ногоон занар байна. Усжилт бага.

Энэ уст үеийн ус нь цэнгэг, 1 г/л хүртэл эрдэсжилттэй. Гидрокарбонат, сульфат-гидрокарбонат-натрийн найрлагатай. Усны ерөнхий хатуулаг нь 3 мг экв/л-ээс хэтрэхгүй. Устөрөгчийн орчин рН=6,8

Тус талбай нь манай орны багавтар хур тунадастай тал хээрийн бүс нутагт багтана. Энд сүүлийн 30-н жилийн дунджаар 150-200 мм хур тунадас унадаг. Хур тунадас нь ихэвчлэн богино хугацаанд аадар борооны хэлбэрээр унах бөгөөд нийт хур тунадасны 70-90% нь 6-8 сард орно.

Энэ бүс нутагт Хулд, Өлзийт сумын цаг уурын харуул, Чойрын цаг уурын станцын ажиглалт, хэмжилтийг авлаа. Энэ цаг уурын станцын 1971-2011 оны ажиглалтаас харахад хоногт орсон аадар бороо 61,0 мм хамгийн их унасан байна.

Ордын хэмжээнд тархсан сэвсгэр хурдасны зузаан 0.1-1.0м-ээс үл хэтрэх ба энэ хурдастай холбоотой ус агуулах горизонт үүсээгүй. Бидний өрөмдсөн цооногууд болон өмнөх судлаачдын өрөмдсөн цооногуудад уст үе илрээгүй. Иймд уг хүдрийн биетэй олборлолтын явцад нөлөөлөх гидрогеологийн хүндрэлгүй болох нь хайгуулын ажлаар нотлогдсон болно.

Тус орд газрын эргэн тойронд 2-8км-ийн радиус дотор 5-6 гар худаг бий. Эдгээр худгуудын ус нь уурхайн ундны болон техникийн усны хэрэгцээг хангах бүрэн боломжтой. “Өлзийт-1” ордын талбайн гидрогеологийн судалгааг хийсэн. Ордын гидрогеологийн нөхцөлийг 35-150м гүн хүртэл судалсан бөгөөд доод цэрдийн түрэлтэт чөлөөт гадаргуутай нүх сүвийн усны уст давхаргад агуулагдсан байна. Гидрогеологийн судалгааны гол арга нь цооногийн шавхалт туршилтын ажил байсан ба тус ордын ус хангамжинд ашиглах худаг 3,0л/сек ундрагатай байна.



Зураг 7. Худаг

2.8. Хөрсөн бүрхэвч

Хөрсний хими болон физик шинжийн задлан шинжилгээгээр химийн үндсэн үзүүлэлтүүд болох хөрсний ялзмагийн хэмжээ, урвалын орчин /рН/, цахилгаан дамжуулах чадвар, хөрсөн дэх хөдөлгөөнт элементүүд болох фосфор, кали, солилцох суурь элементүүд кальци, магни зэргийг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлсний зэрэгцээ механик бүрэлдэхүүнийг ширхэгийн хэмжээний ангиллаар буюу Гидрометрийн аргаар тодорхойлуулж дүнг мөн хүснэгтэд тус тус үзүүлсэн болно.

Хүснэгт 11. Хөрсний химийн үндсэн үзүүлэлт

Дээж	Гүн, см	рН	Давс, %	ЦДЧ, dsm	Ялзмаг, %	CaCO ₂ , %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
							Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Зүсэлт-1	0	10.14	0.02	0.042	0.24	0.00	9.0	4.6	1.7	27
Зүсэлт-2	0	10.64	0.07	0.142	0.22	0.00	8.8	3.3	1.8	25
Зүсэлт-3	0	10.85	0.12	0.276	0.17	0.64	3.9	2.7	0.5	10
Зүсэлт-4	0	10.85	0.33	0.663	0.05	0.64	5.2	2.8	1.1	17

Хүснэгт 12. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Зүсэлт-1	0	15.5	64.0	6.7	3.7	7.2	2.9	13.9
Зүсэлт-2	0	25.1	55.7	3.7	2.2	1.7	11.6	15.5
Зүсэлт-3	0	33.9	37.6	7.4	2.3	11.1	7.7	21.1
Зүсэлт-4	0	23.7	40.0	13.7	4.9	8.8	9.0	22.6

Хөрс нь сул шүлтлэг болон хэт шүлтлэг урвалын орчинтой, карбонат багатай, ялзмагийн агууламж бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж бага, хөдөлгөөнт калийн хангамж бага болон дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага байна. Энд тархсан хөрс элсэнцэр голдуу бүрэлдэхүүнтэй нийт бүрэлдэхүүний 54.2-58.6 %-ийг янз бүрийн ширхэгтэй элс /2-0,05 мм/ бүрдүүлж, тоос болон шаварлагийн зүйл багатай байна.

Хүснэгт 13. Хөрсний хүнд металл

Дээж	Гүн, см	Хүнд металл мг/кг					
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
Зүсэлт-1	0	11.3	ND	28.2	15.3	75.6	17.1
Зүсэлт-2	0	14.4	ND	34.6	31.4	81.4	19.1
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		150.0	3.0	100.0	100.0	300.0	150.0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000.0	10.0	500.0	500.0	600.0	400.0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800.0	20.0	1200.0	1000.0	1000.0	1500.0
Элементедийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт		/MNS 5850:2019/					

2.9. Ургамлын аймаг

Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг нь газарзүйн мужлалаар Төв Азийн говийн их мужид, газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр ухаа гүвээт тэгш талын өндөрлөг хэв шинжид багтана. Талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг нь талбайн урд, зүүн урд захаар орших далайн түвшинээс дээш 1350м-т, хамгийн намхан цэг нь 1300 м-ийн өндөртэй байх бөгөөд харьцангуй өндөршилт 50-150м орчим байна. Толгодууд, гүвээ нь мөлгөр оройтой, аажим налуу хажуутай, уужим тавиу өргөн хөндий хөгжсөн байдаг. Говь, хээрийн бор хөрсний бүслүүрт багтана. Хонхор хотгор газруудаар хужир тойром мараалаг хөрс элбэг тархсан байдаг. Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвст- бударганат хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Харгана, бударгана зэрэг бутлаг ургамал, таана,

хөмөл, монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг. Ургамал ерөнхийдөө сийрэг боловч тачирхан, тэжээллэг чанар сайтай учир бэлчээрийн багагүй ач холбогдолтой.

Судалгаагаар бүртгэгдсэн ургамлуудын нөмрөг бүрдүүлэх байдлыг бүтцийн талаас нь авч үзвэл үетний овог- *Graminae* зүйлийн бүрэлдэхүүнд 22%, нөмрөгт 23%-ийг, луулийн овог- *Chenopodiaceae* зүйлийн бүрэлдэхүүнд 19%, нөмрөгт 23 хувийг, нийлмэл цэцэгтний овог- *Compositae* зүйлийн бүрэлдэхүүнд 16%-ийг нөмрөгт 14%-ийг, сарааны овог- *Liliaceae* зүйлийн бүрэлдэхүүнд болон нөмрөгт 11%-ийг тус бүр эзэлж ургамлан нөмрөгийн шинж бүрдүүлэх үндсэн үүргийг гүйцэтгэж байна.

2.10. Амьтны аймаг

Энэ бүс нутагт нь талын ландшафтын өндөрлөг талын (1200-1300 м хүртэл) бага хэрчигдэлтэй, элэгдлийн умард хуурай хэсгийн ландшафттай. Байгалийн мужлалын хувьд давхаргат өндөрлөг тал, үлдмэл цулдмал уул бүхий говь хээрийн дэд мужийн 10 %-аас бага мараа-марз бүхий Умард хуурай хээрийн районд хамаарна.

Амьтны аймгийг юуны өмнө сээр нуруугүйтэн ба сээр нуруутан гэсэн хоёр үндсэн бүлэгт ялган авч үзэв. Манай орны төв хэсгийн хээрийн ургамалшилттай нутагт олон салаа гүн их малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллогчид мэрэгчид зонхилно.

Зарим зүйлийн мэрэгчид хэт олширсон үедээ хөрс ургамалд сүрхий сөрөг нөлөө үзүүлдэг. Нөгөө талаар газар малтагч жижиг мэрэгч амьтдын үйл ажиллагааны нөлөөгөөр хээрийн хөрс сийрэгжиж, ургамлан нөмрөг нь баяжиж нийтдээ бэлчээрийн ашиг шим дээшилдэгч явдал бий. Хээрийн бүсийн шувуудын бүрдэлд монгол болжмор нилээд хувийг эзэлнэ.

Шавжийн хувьд ядуувтар бүрэлдэхүүнтэй хээрийн шавжны аймгийн төлөөлөгчид тархсан байна.

2.11. Нийгэм- эдийн засгийн байдал

Өлзийт сумын үүсэл хөгжил, газар нутаг, Засаг захиргааны зохион байгуулалт: Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошуу нь 1924 онд явагдсан засаг захиргааны зохион байгуулалтаар аймаг хошуудын нэрийг сольж Богдхан аймгийн Дэлгэрхангай уулын хошууны Өлзийт сумыг Өвөр Дэрсэнэ-Усанд Сүрэнхор занги хэмээх даргатайгаар байгуулсанаас хойш Гүн үнэгэд, тагт зэрэг зэрэг газруудад төвлөрч байснаа ган гачаал, цагийн байдлаас шалтгаалан гуч орчим удаа нүүдэл суудал хийж 1965 онд одоогийн Рашаант хэмээх уул устай газрыг түшиглэж төвлөрөн хөгжиж байна. Говийнхны хэлдгээр “Тэмээний нуруун дээр явсан” тус сумын түүх ингэж эхэлсэн бүлгээ. 1956 оноос эхлэн нутгийн ардууд “Ялалт”, “Хоёрдугаар таван жил” “Дайчин нөхөрлөл” “Хөгжлийн зам”, “Шинэ өрнөлт” “Гучин долоон жил” нэгдлүүдийг бий болгожээ. 1961 онд Өлзийт, Буянт-Овоо сум, тэдгээрийн 6 нэгдлийг нэгтгэж Өлзийт сум “Хоёрдугаар таван жил” нэгдэл хэмээн нэрлэсэн түүхтэй. Ийнхүү өргөн уудам нутаг бүхий өнөөгийн Өлзийт сум бүрэлдэн тогтсон түүх ийм буюу. Өлзийт сум нь хойд талаараа өөрийн аймгийн Хулд, Луус, Сайнцагаан, зүүн талаараа Гурвансайхан, Өндөршил, Дорноговь аймгийн Мандах сумд, урд талаараа Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Цогт-Овоо сумдтай хиллэн оршдог. Сумын төв Рашаант нь Улаанбаатар хотоос 365 км, аймгийнхаа төвөөс 100 км-т байрладаг, сум нь зүүнээсээ баруун хил хүртлээ 220 км, хойноосоо урд хил хүртлээ 160 км сунаж тогтсон 1542,1 мянган га нутаг дэвсгэртэй. Энэ нь Дундговь аймгийн нийт нутгийн 1/5-тэй тэнцэх өргөн уудам нутаг юм. Эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсоны гадна үүрэн телефон Юнителийн сүлжээнд 2008 онд, Жи мобайлийн сүлжээнд 2012 онд холбогдсон байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

"Межик бридж" ХХК-ийн Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Цогзол уулын хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, үргэлжлэх хугацаа зэргийг "Солонгон төгөл" ХХК байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд тодорхойлсон байна.

Хүснэгт 14. Болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийн уялдаа

Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
<i>1. Байгалийн экосистемийн өөрчлөлт</i>										
Газрын доорх урсацын өөрчлөлт		X			X	X			X	
Гадаргын усны урсацын өөрчлөлт		X			X	X				
Ургамлын бүтцийн өөрчлөлт	X				X	X		X		
